БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 24 өдөр Дугаар 101 Номгон

Тээврийн хэрэгсэл худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам"-ын 2.2 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хөгжимт драмын театр, Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Жинст сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд тус тус бүртгэлтэй автомашинуудын худалдах доод үнийг хавсралтаар тогтоож дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Автомашины нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 11^{00} цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд, Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын автомашины үнийг Баянхонгор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх;

2.2. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 12 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

1190159

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын
21-ний өдрийн 101 дүгээр тогтоолын
хавсралт

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Ашиглалтад орсон огноо	Нийт үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг	Дуудлагаар худалдах доод үнэ	Тайлбар
					сери	дугаар						
1	Баянхонгор аймаг	Нэгдсэн эмнэлэг	Пургон машин 92-07 16200.0	УАЗ-220692-033	БНА	92-07	09.12.01	16236000	16236000,00	0,00	1000000	УАЗ-220692-033 маркийн 90001582 хөдөлгүүр, 90495864 арлын дугаартай, 2009 онд үйлдвэрлэгдэж 2019 онд Монгол улсад орж ирсэн Цагаан саарал өнгийн 92-07БНА улсын дугаартай автомашин. Өртгөө 100 хувь нөхсөн.
2	Баянхонгор аймаг	Нэгдсэн эмнэлэг	DONG FENG 01-03 машин	DONG FENG	БНА	01-03	09.12.01	40954500	40954500,00	0,00	3000000	DONG FENG маркийн 2009 онд үйлдвэрлэгдсэн 2009 оны 11 сард Монгол улсад орж ирсэн LJNMFMBX69N042880 арлын дугаартай 01-03 БНА тусгай зориулалттын цагаан өнгийн автомашин.

3	Баянхонгор аймаг	Хөгжимт драмын театр	Toyota Chaser 00-11 БНА	Toyota Chaser	БНА	00-11	11.10.30	12000000	12000000,00	0,00	2000000	Toyoto Chaser маркийн JZX1000116119 арлын дугаартай 2000 онд үйлдвэрлэгдсэн, 2009 онд Монгол улсад орж ирсэн 00-11БНХ улсын дугаартай цагаан өнгийн суудлын автомашин.2011 онд худалдан авсан, байгууллагын дотор хэрэгцээнд ашиглаж байсан, цахилгааны холбоос нь шатсан.
4	Баянхонгор сум	ИТХ	Toyota BREVIS	Toyota BREVIS	БНХ	86-61	14.12.31	11492000	9257444,38	2234555,62	2234560	Toyota BREVIS маркийн JCG150005370 арлын дугаартай 2003 онд үйлдвэрлэгдсэн 2012 онд Монгол улсад орж ирсэн 86-61 БНХ улсын дугаартай цагаан өнгийн суудлын автомашин. 2014 онд ашиглалтад орсон 11492,0 мянган төгрөгийн анхны үнэтэй 2234,5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй.Уг тээврийн хэрэгсэл эвдрэл ихтэй шатахуун өндөр зарцуулдаг, засвар үйлчилгээ хийлгэсэн ч засвар сайн авдаггүй, байнга засвар хийх төсөв хөрөнгө муутай байдаг.

5	Жинст сум	ЗДТГ	Суудлын	Ланд круйзр-80	БНА	91-23	15.07.05	22500000	14785811,02	7714188,98	7714200	Toyoto land cruiser80 маркийн 1996 онд үйлдвэрлэгдсэн 2008 онд Монгол улсад орж ирсэн, HDJ810030587 хөдөлгүүрийн дугаартай, 91-23БНА улсын дугаартай ногоон өнгийн автомашин. 4 аммартизатор ажилдаггүй, аккумлятор 2 ширхэг суусан, халаагч ажиллахгүй, турбо, хөөх помт ажиллахгүй, бөгсний шаариг араа эвдэрсэн, 4 дугуй язарч муудсан, кроп эвдрээд урагшаа явахаа болиод тависан. Хуучин кроп авахад 4,0 сая төгрөг шаардлагатай.2018 оны 10 сард явахаа болиод зогссон.
			Дүн					**103182500**	**93233755,40**	**9948744,60**	**15948760**	

oOo